



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/57


Ховд

Бүтэц орон тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Орон нутгийн өмчийн газар /Худалдан авах ажиллагааны албатай/-ын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.
2. Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын ажил үүргийн хуваарь, хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлж, албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны салбар зөвлөлөөр хянуулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0333

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 28-ны өдрийн
захирамжийн хавсралт



АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/д	Бүтэц	Орон тоо
1	Орон нутгийн Өмчийн газрын дарга	1
2	Өмчийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Орон нутгийн өмчийн сан хариуцсан мэргэжилтэн	1
4	Орон нутгийн өмчит хуулийн этгээд хариуцсан мэргэжилтэн	1
5	Өмчийн бүртгэл хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн	1
6	Худалдан авах ажиллагааны албаны дарга	1
7	Худалдан авах ажиллагаа, цахим систем хариуцсан ахлах мэргэжилтэн	1
8	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, сум хариуцсан мэргэжилтэн	1
9	Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн	1
10	Худалдан авах ажиллагааны сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1
11	Нягтлан бодогч, хүний нөөц, бичиг хэрэг	1
12	Жолооч, нярав	1
	Нийт	12